



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/74

Хэрлэн сум

“Хэнтийн манлайлагч залуус” төрийн бус
байгууллагад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хэнтийн манлайлагч залуус” төрийн бус байгууллагаас тавьсан хүсэлтийн дагуу Хан Хэнтий уулын аймаг үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ой, “Үзэсгэлэн болгогч” хэмээх туулай жилийн цагаан сарын баярыг угтан хүүхэд, залууст үндэсний өв соёлоо сурталчлан таниулах зорилготой “Мэнд амар” контент, нэвтрүүлгийг зохион байгуулахад 6,000,000 (зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ